

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Жамбал	Дугаар	L261
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Баянцагаан сум
Төрсөн газар	Баянцагаан сум	Төрсөн он	1928
Ажил мэргэжил	Өндөр настан		
лЛам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дарьгиатын хийд	Сүм хийдийн дугаар	ТӨБЦ 002
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-рсарын 13	Ярилцлага авсан хүн	Жужа

Төв аймгийн Баянцагаан сумын Дарьгиатын жас

Жужа: Та шавилан сууж байсан Дарьгиатын хийдийн тухай ярьж өгөхгүй юу?

Жамбал: Шавилах ч юу байхав, жаахан хүүхэд ном заалгаж байсан юм.

Жужа: Хэдэн лам хэдэн дугантай байсан бэ?

Жамбал: Аа мэдэхгүй, 10-аад өвгөчүүл нэг л дугантай байсан.

Жужа: Суварга байсан уу?

Жамбал: Суварга байгаагүй.

Жужа: Нийт ламын тоо ер нь хэд байсан юм бол?

Жамбал: Ер нь л арваас давахгүй байсан байх.

Жужа: Хэдэн жастай байсан бэ?

Жамбал. Нэг л жастай байсан.

Жужа: Тэр ганц дуган нь модон дуган байсан уу?

Жамбал: Аан ер нь л модон дуган байсан байх. Дугуй модон дуган л байсан.

Энхбаяр: Тэр гэрийн буурь шиг туурь дуганы туурь уу?

Жамбал: Тийм, тэр дуганы туурь. Та нар тэрүүгээр орсон юм уу?

Жужа: Яг тэр газрын нэр юу вэ?

Жамбал: Бурхант гэдэг газар.

Жужа: Аль овоогоо тахидаг байсан бэ?

Жамбал : Аа тэрүүхэн баруунтай Мандал овоо гэж овоо бий. Түүнийг тахидаг байсан.

Жужа: Тэнд ямар нэг худаг ус бий юу?

Жамбал: Нэлээн баруунтай тэр Мандал овоог тойроод Хөх хошуу гэж ус бий.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Тийшээ Манхан уул гэж байдаг уу?

Жамбал: Манхан уул гэж бий. Тэр түүрийн чинь баруун өмнөхөн баруун, зүүн Манхан гэж хоёр Манхан уул бий.

Жужа: Хийдийн хамба ямар хүн байв?

Жамбал: Магсар гэж лам байсан.

Жужа: Хамба уу, ловон уу ямар хэргэмтэй хүн байв?

Жамбал. Хамба нь байсан байх аа. Миний л багш байсан. Би хүүхэд байхдаа ном заалгаж байсан юм.

Жужа: Гол шүтээн ямар сахиустай байсан бэ?

Жамбал: Мэдэхгүй ээ. Гомбо, махгал л байсан юм байж дээ.

Жужа: Лам нар тогтмол тэнд байдаг уу, аль эсвэл хөдөөнөөс ирдэг байсан уу?

Жамбал: Голдуу л тэндээ суудаг байсан. Тогтмол л хуралтай байсан болохоор.

Жужа: Ямар ямар хурал хурдаг байсан юм бол?

Жамбал: тэрнийг бол ёстой мэдэхгүй. Юу юу хурдаг байсан юм, цогчин лав хурдаг байсан.

Жужа: Энэ жасын ойролцоо өвөр 3 жас гэж байсан уу?

Жамбал: Байсан. Өвөр гурван жас гэж нэг дугантай жас байсан юм.

Жужа: Өвөр гурван жас танай харъяа байсан уу, тусдаа байсан уу?

Жамбал: Үгүй манайхаас тусдаа бие даасан жас байсан.

Жужа: Тэр Өвөр гурван жас хуучин засаг захиргааны бүтцээр Дайчин бэйсийн хошуунд орох уу, Цэцэн вангийн нутагт орох уу?

Жамбал: Дайчин бэйсийн хошуунд орохгүй юм аа. Цэцэн вангийн хошуундаа л орох болов уу.

Жужа: Өөр энэ хавьд Дэлгэр Өлзийтийн хурал гэж байсан уу?

Жамбал: Байсан юм, энэ хойшоо .

Жужа: Эндээс хол уу?

Жамбал: 30-аад км орчимд хойшоогоо туурь нь байгаа.

Жужа: Дарьгиатын жас хэдэн онд хаагдсан юм бэ?

Жамбал: Мянга есөн зуун гучин хэдэн он, би ч 13 хүрээгүй л байсан. 1927 оноос хойш 1937, 1938 оны үед юм уу, тэр орчимд хаагдсан.

Жужа: Та хэдэн онд шавилах болсон юм бэ?

Жамбал: 6, 7-тойдоо суугаад л 4 жил суусан.

Жужа: Дарьгиатын жасд гэсгүй байсан юм уу?

Жамбал: Байлгүй яахав, нэг гэсгүй байсан.

Энхбаяр: Том лам нар 10 орчим байсан, хүүхэд багачууд хэд орчим байсан юм бэ?

Жамбал: 3-4 хүүхэд л байсан.

Жужа: Ганжуур байсан уу?

Жамбал: Мэдэхгүй ээ, тогтмол хуралтай байсныг бодоход байсан юм байлгүй.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Та хэдэн онд дахиад лам болсон бэ?

Жамбал: Би одоо бол лам биш, хүүхэд байхдаа ном үзэж байгаад л тэрнээс хойш таг хаясан.

Жужа: Дарьгиатын жасад сууж байсан өөр лам нар одоо бий юу?

Жамбал: Байхгүй, байхгүй.

Энхбаяр: Яг одоо лам байгаагүй ч энэ хавийн жас хурлуудын тухай мэдэх тийм настай хүмүүс байна уу?

Жамбал: Байхгүй ээ, одоо ч ховордож. Уг нь та нар сайхан судалгааны ажил хийж байгаа юм байна. Даанч оройтож, настай хүмүүс нь үнэхээр мэдэх хүмүүс нь одоо ховордчихсон.